2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, гүйцэтгүүлсэн үйлчилгээний төлбөр, хураамж	185,274,400.00	186,321,358.68	-1,046,958.68	100.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,586,900.00	156,333,218.00	-5,746,318.00	103.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900,000.00	1,900,000.00	0	100
210803	Даатгалын үйлчилгээ	6,159,400.00	6,159,400.00	0	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	494,800.00	472,510.68	22,289.32	95.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	363,000.00	330,000.00	33,000.00	90.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	197,900.00	197,880.00	20	100
210807	Газрын төлбөр	4,123,500.00	4,123,425.00	75	100
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,448,900.00	16,804,925.00	4,643,975.00	78.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194595700	189885400	4,710,300.00	97.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,595,700.00	189,885,400.00	4,710,300.00	97.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34180000	21802272	12,377,728.00	63.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	0	0	
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,180,000.00	21,802,272.00	12,377,728.00	63.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,180,000.00	21,802,272.00	12,377,728.00	63.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,279,203,900.00	16,103,492,780.56	175,711,119.44	98.9
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,829,581,200.00	15,609,396,699.56	220,184,500.44	98.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,829,581,200.00	15,609,396,699.56	220,184,500.44	98.6
100000	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	424,622,700.00	468,096,081.00	-43,473,381.00	110.2
1000000	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	382,622,700.00	453,307,081.00	-70,684,381.00	118.5
1000000	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,000,000.00	14,789,000.00	27,211,000.00	35.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	4,824,367.00	-4,824,367.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	122,107,244.00	-122,107,244.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	413	413		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	363	363		
620003	Үйлчлэх ажилтан	49	49		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	413	413		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	12,807,710.56
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	31,515,779.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	31,515,779.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	31,515,779.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	3,138,030.00
210404	Ном, хэвлэл	0.00	3,138,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,857,500.00
210604	Урсгал засвар	0.00	1,857,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	11,890,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	11,890,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	14,629,949.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	14,629,949.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	18,708,068.44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		18,708,068.44
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2022 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 4 дүгээр сарын 08-нд Хөвсгөл аймгийн Засаг даргын 197 дугаар захирамжаар байгуулагдсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд 7 удаа хуралдаж 37 асуудлыг хэлэлцэж 18 тогтоол шийдвэрийг гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Нэгдсэн эмнэлгийн захирлын даргын 2022 оны 10 сарын 4-ны өдрийн А/9 тоот тушаалаар дотоод хяналтын баг 8 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 3 заалт бүхий хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт улиралд 3-4 удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

¹ “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

² “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Мөн Дотоод хяналт-аудитын албыг 2022 оны 06 дугаар сард орон тооны 2 ажилтантай, орон тооны бус 3 гишүүнтэйгээр байгуулагдсан ба 4 төрлийн 23 чиглэлээр хяналт хийхээр төлөвлөсөн ба хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Нэгдсэн эмнэлэг нь 2022 онд “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулж Нэгдсэн эмнэлгийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны А/115 тушаалаар батлуулан санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэ нь санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 703,846.6 мянган төгрөгөөр буюу 4,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,632.1	122,107.2	-104,475.1
Авлага	2,260,812.5	0	2,260,812.5
Бараа материал	1,229,333.9	2,125,631.5	-896,297.6
Үндсэн хөрөнгө	15,550,085.9	17,517,409.7	-1,967,323.8
Нийт хөрөнгө	19,061,301.9	19,765,148.5	703,846.6
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,126,931.2	7,126,931.2	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	19,061,301.9	19,765,148.5	703,846.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материалын данс, үндсэн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, авлага буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 104,475.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 896,297.6 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлт мөн Эрүүл мэндийн яамнаас ирсэн ковидын үеийн хамгаалах хэрэгсэл оношлуур эм тариа ирсэнтэй холбоотой үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 1,967,323.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 298,929.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 2,283,630.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсөл хандив тусламжаар 336,101.6 мянган төгрөг, 0 үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж дахин үнэлсэн хөрөнгийг орлого авсан 678,818.7 мянган төгрөг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны А/92 дугаар захирамжаар 76,556.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 2,260,812.5 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал 15,609,396.4 мянган төгрөг, Үндсэн үйл ажиллагааны орлогоос 453,307.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн төслийн саналаас цалин нэмэгдэл хөлсийг 360,000.0 мянган төгрөгөөр өсгөж, 585,900.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 360,000.0 мянган төгрөгөөр өсгөж тодотгосон байна. Энэ нь ажилчдын цалинг 15-20 хувиар өсгөсөнтэй холбоотой. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 16,103,500.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 15,609,396.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 453,307.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 15,986,209.9 мянган төгрөг буюу 98,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 292,994.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал 80101	16,220,023.9	15,939,407.6	280,616.3	98.2%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 80802	34,180,0	21,802,3	12,377,7	63,8%
	Дээд шатны төсвөөс хуваарилсан	25,000,0	25,000,0	0	100%

3	83603				
		16,279,203.9	15,986,209.9	292,994.0	98.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2022 оны жилийн эцсээр үлдэгдэлгүй тайлагнасан ба гүйцэтгэлээр санхүүжиж байгаа Эрүүл мэндийн байгууллагуудын нэмэлт дансыг улсын төсвийн үндсэн данс руу нэгтгэсэн.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 15,638,815.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 312,776.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 218,943.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан

томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар ТУЗ-ийн гишүүдэд 2021 онд нийт 22,950.0 мянган төгрөгийн урамшуулалд даатгуулагчаас суутган төлөх 2,693.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх 2,922.7 мянган төгрөг нийт 5,616.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж төлөөгүйд 1 төлбөрийн акт тогтоож, албан шаардлага өгөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, Шилэн дансны мэдээллийг дутуу оруулсан тул аудитаар 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг ханган биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,616.0	1	5,616.0	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Нийт дүн	2	5,616.0	2	5,616.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер

зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 142,016.4 мянган төгрөгийн эмийн шууд худалдан авалт хийсэн байна.

- Гүйцэтгэлээр санхүүжиж буй байгууллага нь Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу санхүүжих бөгөөд Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого зардлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан төсвийн сахилга батыг мөрдөж хэрэгжүүлэн ажиллахаар хуульчилсан байна. Гэвч аймгийн Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа тул Төсвийн тухай хууль хамааралгүй гэх ойлголттой байгаа тул цаашид төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль журмыг мөрдөн ажилласан эсэхэд анхаарал хандуулах.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 153,926.1 мянган төгрөгийн алдаа³ зөрчил⁴ илэрснээс аудитын явцад залруулсан алдаа байхгүй, 114,051.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 39,875.1 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал илрээгүй тул залруулга хийгдээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 10-ны 15 тогтоолоор өндөр өртөгтэй тусламж үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх, нутагшуулахад ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 160,178.0 мянган төгрөгийн 2 өрөө 2 шинэ хуучин орон сууц худалдан авах тогтоол гаргасан ба 2022.09.12-ны 12-р тогтоолоор шинэ байрны м2 үнийг 400.0 мянган төгрөг буюу 23,373.0 мянган төгрөгөөр нэмж 114,051.0 мянган төгрөгийн байр худалдан авсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах: гэсэн заалттай нийцэхгүй байгаа нь үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас Өсөх прогресс ХХК-д 22,750.0 мянган төгрөгийн кино контент, Б.Дамдинсүрэнд /ШД 85020111/ -д 3,000.0 мянган төгрөгийн сурталчилгаа хийсэн нийт 25,750.0 мянган төгрөг зарцуулж гэрээ дүгнээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Иргэдэд Эрүүл мэндийн боловсрол олгох болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулахдаа нэршлийг оновчтой сонгож үр дүнг тооцож ажиллах.

2. Боловсон хүчний асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь орон тооны мэдээгүйжүүлэгчийн эмч байхгүй тул Улаанбаатар хотоос Хавдрын эмч, сэхээн амьдруулах эмч нар авчирч буудалд байрлуулсан хөлс 9,266.1 мянган төгрөг, байр түрээсэлсний хөлс 4,859.0 мянган төгрөг нийт 14,125.1 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутагт нэн шаардлагатай Мэдээгүйжүүлэлтийн эмч болон бусад нарийн мэргэжлийн эмч нарыг дадлагажуулан сургаж орон тооны тогтвор суурьшилтай ажиллуулж мэргэшсэн боловсон хүчинтэй болж хүний нөөцийн асуудлыг яаралтай шийдвэрлэж төсвийг үр ашигтай зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг хэмнэлтийн дагуу зарцуулах	3	153,926.1			1	114,051.0	2	39,875.1				
Дүн	3	153,926.1			1	114,051.0	2	39,875.1				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО: